



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын аварга шалгаруулах
чансаа өндөр бөхчүүдийн 3х3 багийн
барилдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/531 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын аварга шалгаруулах чансаа өндөр бөхчүүдийн 3х3 багийн барилдааныг 2025 оны 04 дүгээр сарын 20, 27-ны өдөр Монгол бөхийн өргөөнд зохион байгуулсугай.

2.Улаанбаатар хотын аварга шалгаруулах чансаа өндөр бөхчүүдийн 3х3 багийн барилдааныг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Улаанбаатар хотын аварга шалгаруулах чансаа өндөр бөхчүүдийн 3х3 багийн барилдааныг зохион байгуулахад шаардагдах 80,000,000 (наян сая) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын нэмэлт дансны холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний урьдчилсан бэлтгэл ажлыг сайтар хангаж, нийслэлийн иргэдийг өргөнөөр хамруулан зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны
өдрийн 117 дугаар тушаалын хавсралт

Улаанбаатар хотын аварга шалгаруулах
чансаа өндөр бөхчүүдийн 3х3 багийн
барилдааныг зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.	Хэсгийн барилдааны давааны шагнал	81	250,000	20,250,000
2.	Шигшээ барилдааны давааны шагнал	27	400,000	10,800,000
3.	Хувийн дүнгээр буюу давааны тоогоор тэргүүлэгч бөхийн шагнал	1	5,000,000	5,000,000
4.	Түрүүлсэн багийн шагнал	1	15,000,000	15,000,000
5.	Дэд байрт шалгарсан багийн шагнал	1	10,000,000	10,000,000
6.	Гутгаар байрт шалгарсан багийн шагнал	1	5,000,000	5,000,000
7.	Зохион байгуулагч, шүүгч	2 хүн x 2 өдөр	400,000	1,600,000
8.	Хяналтын цэц	1 хүн x 2 өдөр	300,000	600,000
9.	Хөлийн цэц	4 хүн x 2 өдөр	250,000	2,000,000
10.	Тайлбарлагч	2 хүн x 2 өдөр	350,000	1,400,000
11.	Гарын даа	2 хүн x 2 өдөр	300,000	1,200,000
12.	Засуул	6 хүн x 2 өдөр	250,000	3,000,000
13.	Эмч	2 хүн x 2 өдөр	200,000	800,000
14.	Тэмдэглэл хөтлөгч	1 хүн x 2 өдөр	200,000	400,000
15.	Өсгөл шалгагч	1 хүн x 2 өдөр	200,000	400,000
16.	Хамгаалагч	6 хүн x 2 өдөр	80,000	960,000
17.	Медаль	5 хүн x 3 ш	40,000	600,000
18.	Өргөмжлөл	15 ш	30,000	450,000
19.	Бусад зардал	-	-	540,000
Нийт дүн				80,000,000